

“Албан журмын даатгагчдын холбоо” ГҮТББ

Хараат бус Аудиторын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр



МОНГОЛЫН
АМГААГАГЧ
ДЫН ХОЛБОО

Албан журмын даатгагчдын холбоо ТББ

Албан журмын даатгагчдын холбоо ТББ	0
1. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	1
2. АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
3. АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН.....	5
4. АУДИТЛАГДСАН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	6
5. АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	7
6. АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8
7. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	9
7.1 Байгууллагын талаарх мэдээлэл.....	9
7.2 Байгууллагын үйл ажиллагааны эдийн засгийн болон эрх зүйн орчин.....	9
7.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд.....	9
7.4 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10
7.5 Авлага	11
7.5.1 Татвар НДШ-ийн авлага.....	12
7.6 Урьдчилж төлсөн тооцоо/зардал	12
7.7 Бараа материал.....	13
7.8 Үндсэн хөрөнгө.....	13
7.9 Биет бус хөрөнгө.....	15
7.10 Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	16
7.11 Өр төлбөр.....	16
7.11.1 Дансны өглөг	17
7.11.2 Татварийн өр	17
7.12 Цэвэр хөрөнгө буюу өөрийн хөрөнгө.....	17
7.14 Орлого, зардал.....	18
7.14.1 Борлуулалтын орлого.....	19
7.15 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага.....	20
8. АУДИТЫН ТАЙЛАН.....	21
8.1 Ерөнхий зүйл	21
8.2 Материаллаг байдал	21
8.3 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд	21
8.4 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	22
8.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24



“Албан журмын даатгагчдын
холбоо” ГҮТББ-д

“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

РАССЕЛ БЕДФОРД ИНТЕРНЭШНЛ

олон улсын сүлжээний гишүүн

2025.02.10 № 25/12

танай _____ -ны № _____ -т

АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Албан журмын даатгагчдын холбоо” ГҮТББ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээр тасалбар болсон тухайн жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудыг багтаасан санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгаас бүрдсэн хавсралтад буй санхүүгийн тайлангуудыг нягтлан шалгалаа.

Бидний гүйцэтгэсэн нягтлах ажлын үр дүнг үндэслэн дүгнэхэд дээрх санхүүгийн тайлангуудыг бүх материаллаг зүйлсийн хувьд Жижиг дунд аж ахуйн нэгжийн Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу “Албан журмын даатгагчдын холбоо” ГҮТББ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, жилийн эцсээр тасалбар болсон тухайн жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулаагүй (*эсвэл зөв, бодитой ойлголт өгөөгүй*) гэж үзэх зүйл бидний анхааралд өртөөгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү дүгнэлтийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.
- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.

Хараат бус аудитын дүгнэлтийн үргэлжлэл

- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх.
- Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

(Энэхүү дүгнэлт нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)

ЗАХИРАЛ




Д.ШИЙРЭВ

АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"Албан журмын даатгагчдын холбоо" ГҮТББ

Балансын зүйл	2024.12.31	2023.12.31
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	197,246,178.4	74,600,185.4
Богино хугацаат хөрөнгө оруулалт	12,138,646,096.6	11,858,224,152.2
Дансны авлага	6,466,119,877.4	6,088,788,243.9
Найдваргүй авлагын хасагдуулга	(81,075,597.0)	-
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,945,201.0	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	18,724,881,756.4	18,021,612,581.5
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,586,369,834.3	1,638,683,900.6
Биет бус хөрөнгө	89,586,286.5	124,956,929.1
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	118,649,000.0	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,794,605,120.8	1,763,640,829.7
Нийт хөрөнгийн дүн	20,519,486,877.2	19,785,253,411.1
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	2,420,216.0	2,104,408.0
Татварын өр	22,545,913.8	280,000.0
Урьдчилж орсон орлого	701,317.2	199,000.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	25,667,447.0	2,583,408.0
Урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	25,667,447.0	2,583,408.0
Цэвэр хөрөнгө		
Нөөц: а) хязгаарлалтгүй	10,000,000.0	10,000,000.0
б) хязгаарлалттай	20,477,955,161.7	19,759,857,031.8
Цэвэр хөрөнгө өмчийн бусад хэсэг	5,864,268.5	12,812,971.3
Эздийн өмчийн дүн	20,493,819,430.2	19,782,670,003.1
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	20,519,486,877.2	19,785,253,411.1



АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"Албан журмын даатгагчдын холбоо" ГҮТББ

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
Үндсэн үйл ажиллагааны орлого		
Жолоочийн даатгалын сангийн эх үүсвэр	2,708,171,518.2	2,493,357,300.5
Үйл ажиллагааны орлогын дүн	2,708,171,518.2	2,493,357,300.5
Ерөнхий ба удирдлагын зардал	1,295,589,425.6	973,730,087.5
Бусад зардал	509,786,389.3	10,649,153,595.5
Орлогын татварын зардал	184,697,573.5	171,271,178.6
Үндсэн үйл ажиллагааны нийт зардлын дүн	1,990,073,388.4	11,794,154,861.6
Үндсэн үйл ажиллагааны үр дүн	718,098,129.8	(9,300,797,561.1)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/алдагдал	(6,948,702.8)	(11,851,186.6)
Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг/алд	(6,948,702.8)	(11,852,590.6)
Торгууль, хөнгөлөлтийн ашиг/алдагдал		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	1,404.0
Тайлант үеийн цэвэр үр дүн	711,149,427.1	(9,312,648,747.7)



АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"Албан журмын даатгагчдын холбоо" ГҮТББ

ҮЗҮҮЛЭЛТ	Хязгаарлалтгүй нөөц	Хязгаарлалттай нөөц	Цэвэр хөрөнгө өмчийн бусад хэсэг	Нийт дүн
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	10,000,000.0	19,759,857,031.8	12,812,971.3	19,782,670,003.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	10,000,000.0	19,759,857,031.8	12,812,971.3	19,782,670,003.1
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		718,098,129.8	(6,948,702.8)	711,149,427.1
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	10,000,000.0	20,477,955,161.7	5,864,268.5	20,493,819,430.2



АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

"Албан журмын даатгагчдын холбоо" ГҮТББ

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	657,387,438.6	653,670,414.7
Гишүүний татвараас орсон орлого	17,000,000.0	15,000,000.0
Даатгалын сангийн орлого	640,387,438.6	638,670,414.7
Мөнгөн зарлагын дүн	2,059,512,930.1	11,785,038,269.2
Ажиллагчдад төлсөн	490,006,760.6	331,120,494.0
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	118,958,439.1	98,520,070.7
Ашиглалтын зардалд төлсөн	42,723,878.8	83,148,856.5
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлс	118,311,950.0	18,396,360.5
Бусад зардалд төлсөн	941,524,320.6	10,863,485,945.6
Татвар төлбөрт төлсөн	241,838,181.2	222,888,091.9
Даатгалын төлбөрт төлсөн	106,149,400.0	167,478,450.0
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,402,125,491.6)	(11,131,367,854.5)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	18,031,244.0	9,232,313,554.5
Худалдсан хөрөнгийн орлого	18,031,244.0	95,181,502.0
Худалдсан хөрөнгө оруулалт	-	9,137,132,052.5
Мөнгөн зарлагын дүн	340,235,644.4	32,943,374.0
Хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	59,813,700.0	32,943,374.0
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	280,421,944.4	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(322,204,400.4)	9,199,370,180.5
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хүү ба урамшууллын орлого	1,846,975,885.0	1,712,532,752.5
Валютын ханшны зөрүү	-	1,404.0
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,846,975,885.0	1,712,534,156.5
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	122,645,993.1	(219,463,517.5)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	74,600,185.3	294,063,702.8
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	197,246,178.4	74,600,185.3



7. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

7.1 Байгууллагын талаарх мэдээлэл

"Албан журмын даатгагчдын холбоо" ГҮТББ нь 2011 оны 11 дугаар сарын 25-ны өдөр, улсын бүртгэлийн 9072004107, регистрийн 8061866 дугаартайгаар Улсын бүртгэлд бүртгэгдсэн.

Үйл ажиллагааны төрөл болон зорилго:

Албан журмын даатгалыг төлөвшүүлэх, даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагчдыг нэгтгэх, гишүүд, албан журмын даатгалын хохирогчдын эрх ашгийг хамгаалах.

Албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-хороо, Чингисийн өргөн чөлөө, 17 Гэрэгэ тауэр оффис 12 давхар, Утас 70101177

Дүрмийн сангийн хэмжээ: 10,000,000.0 төгрөг

Компанийн Гүйцэтгэх захирал: М.Өлзийбат Харилцах утас: 99190710

Ерөнхий нягтлан бодогч Б.Соёлмаа Харилцах утас: 99085584

7.2 Байгууллагын үйл ажиллагааны эдийн засгийн болон эрх зүйн орчин

Монгол улсад өнөөдрийн байдлаар тус холбооны санхүүгийн үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой дараах хуулиуд үйлчилж байна.

- Иргэний хууль
- Даатгалын тухай хууль
- Төрийн бус байгууллагын тухай хууль
- Жолоочийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Архивын тухай хууль
- Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журам, заавар, аргачлалууд

7.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

Тайлан бэлтгэх үндэслэл.

"Албан журмын даатгагчдын холбоо" ГҮТББ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (НББОУСХ)-оос баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, тогтоомжууд, Сангийн Яам болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан заавар журам, аргачлалын дагуу бэлтгэгдсэн.

Бодит үнэ цэнэ нь хэмжилтийн өдөр зах зээлд оролцогч талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө худалдах, эсхүл хөрөнгө солилцох, өр төлбөр барагдуулахад төлөх үнэ юм. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь идэвхтэй зах зээлийн жишиг үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө ба өр төлбөртэй холбоотой үнийн талаарх хангалттай их хэмжээгээр гүйлгээнүүдийн талаарх мэдээллийг байнга авч болох газрыг хэлнэ.

Анхны өртөг гэдэг нь худалдан авалтын өдөр төлөгдсөн мөнгөн хөрөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийн дүн, эсхүл хөрөнгө худалдаж авахад зориулагдсан бусад нөөцийн бодит үнэ бөгөөд үүнд хэлцэл болон ажил гүйлгээний зардлууд орно.

Аккруэл суурь нь: ажил гүйлгээ үйл явдлыг гарсан буюу тохиолдсон үед нь (мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хүлээн авсан эсвэл төлсөнөөс үл хамааран) хүлээн зөвшөөрөхийг хэлнэ.

Тасралтгүй байх зарчим нь: байгууллага одоо үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд урьдчилан харж болох ирээдүйд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна гэсэн төсөөллийг хэлнэ.

7.4 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийг нэрлэсэн үнээр бүртгэнэ. Харин гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн хувьд анх хүлээн зөвшөөрөхдөө нэрлэсэн үнээр нь бүртгэхээс гадна НББОУС 21-д заасны дагуу тухайн ажил гүйлгээг тухайн өдрийн Монгол банкнаас тогтоосон албан ханшаар төгрөгт хөрвүүлж валют, төгрөгөөр давхар бүртгэнэ.

Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд 3 сараас дээшгүй хугацаатай, тодорхой мөнгөн дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай, харьцангуй эрсдэл бага байдаг богино хугацаат хөрөнгө оруулалтыг хамааруулна.

- Бэлэн мөнгө (касс):
- Банкин дахь бэлэн мөнгө (харилцах):
- Хугацаагүй мөнгөн хадгаламж:
- Замд яваа мөнгө:
- Хязгаарласан мөнгө:
- Банкны карт дахь мөнгө:

7.4.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

	2024.12.31	2023.12.31
Харилцах Төрийн банк/төгрөг/	93,580,417.9	53,300,040.4
Харилцах Хаан банк/төгрөг/	97,801,492.0	8,487,173.7
Харилцах Голомт банк/төгрөг/	5,964,268.5	12,812,971.3
Дүн	197,246,178.4	74,600,185.3

Харилцах дансаар тус холбооны өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гүйлгээг хийж гүйцэтгэдэг.

7.4.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Үнэ цэнийг өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, 3 сар ба түүнээс богино хугацаатай хөрөнгө оруулалтыг хэлнэ. Албан журмын даатгалын хэлбэр тус бүрээр сангуудыг байршуулдаг бөгөөд сан тус бүр нь бие даасан данстай.

Даатгалын сангийн хөрөнгийн 82.3 хувийг арилжааны банкны хадгаламжид, 16.5 хувийг Бичил глобус ББСБ ХХК-ийн гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон Сэндли ББСБ ХХК-д итгэлцлийн гэрээгээр хөрөнгө оруулсан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 2131 дугаар тогтоолоор

баталсан “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ыг 98.8% хангасан.

	2024.12.31	2023.12.31
Хадгаламж /Төрийн банк/төгрөг/	5,268,646,096.6	975,421,548.1
Хадгаламж Голомт банк/төгрөг/	4,720,000,000.0	5,720,000,000.0
Хадгаламж Хаан банк/төгрөг/		5,162,792,604.1
Сэндли ББСБ ХХК /төгрөг/ итгэлцэл	1,150,000,000.0	
Бичил Глобус ББСБ ХХК /төгрөг/ ХБҮЦ	1,000,000,000.0	
Дүн	12,138,646,096.6	11,858,224,152.2

7.5 Авлага

Авлага гэдэг нь компанийн хэвийн үйл ажиллагааны үр дүнд үйлчлүүлэгчид болон худалдан авагчдад зээлээр бараа бүтээгдэхүүн борлуулах, ажил үйлчилгээг гүйцэтгэх явцад үүссэн хөрөнгийг хэлнэ.

Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна.

Авлагын цэвэр дүн нь дансны авлагын нийт дүнгээс найдваргүй авлагын хасагдуулгыг

хассантай тэнцүү байна. Найдваргүй авлагын нөөцийг тооцохдоо авлагын насжилтанд үндэслэн хувийн жингийн аргыг хэрэглэнэ. НБББББ-т тусгаснаар найдваргүй авлагын нөөц санг дараах байдлаар байгуулж ажиллана.

Авлагыг цаг хугацаанаас хамааруулан дараах байдлаар ангилна. Үүнд:

- Эргэлтийн буюу богино хугацаат авлага: Богино хугацаатай буюу нэг жилийн дотор цуглуулагдах бараа, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлбөрийг хэлнэ.
- Эргэлтийн бус буюу урт хугацаат авлага: Ихэвчлэн хөрөнгө оруулалтын шинж чанартай борлуулалтын бус урт хугацааны үйл ажиллагаатай холбогдон бий болж байгаа нэг жилээс дээш хугацаанд цуглуулагдах авлагыг хэлнэ.

Авлагыг төлөгдөх байдлаар нь дараах байдлаар ангилна.

- Хэвийн
- Хэвийн бус
- Хугацаа хэтэрсэн авлага гэж ангилна.

Найдваргүй авлагын нөөцийг тооцохдоо авлагын насжилтанд үндэслэн хувийн жингийн аргыг хэрэглэнэ. НБББББ-т тусгаснаар найдваргүй авлагын нөөц санг дараах байдлаар байгуулж ажиллахыг шаарддаг.

ДД	Авлагын ангилал	Буцаан төлөх хугацаа хэтэрсэн хоног
1	Хэвийн	Төлөгдөх хугацаандаа байгаа болон 15-30 хоног хэтэрсэн
2	Анхаарал хандуулах	90 хүртэлх хоног
3	Хэвийн бус	91-180 хоног
4	Эргэлзээтэй	181-360 хоног
5	Муу	361 хонгоос дээш хонгоос хугацаа хэтэрсэн болон харилцагч нас барсан

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
Харилцагч байгууллагаас авах авлага	765,254,186.8	212,921,826.3
Ажилчдаас авах авлага	5,842,883.0	5,974,967.0
Хувь хүмүүсээс авах авлага	142,031,284.9	187,288,097.0
Барьцааны авлага	532,000.0	532,000.0
Чингис хаан банкнаас авах авлага	5,439,844,878.74	5,682,071,353.6
Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас авах авлага	112,614,643.94	
Дүн	6,466,119,877.4	6,088,788,243.9

Дансны авлагад тусгагдсан 765,254,186.8 төгрөгийн хувьд харилцагч байгууллага буюу даатгалын компаний даатгалын зуучлагч болон даатгалын байгууллагуудаас авах авлага байна. Хувь хүмүүсээс авах авлага дансанд тусгагдсан 142,031,284.9 төгрөгийн хувьд даатгалын нөхөн төлбөрт олгосон буруутай этгээдээс авах авлага байна. Бусад авлага дансанд "Чингис хаан банк ХХК", "Үндэсний хөрөнгө оруулалтын банк ХХК"-д байршуулсан хугацаа хэтэрсэн хадгаламжийн авлагыг тусгасан байна.

7.5.1 Татвар НДШ-ийн авлага

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
ХАОАТ-ын авлага	1,313.0	1,313.0

7.6 Урьдчилж төлсөн тооцоо/зардал

Урьдчилж төлсөн тооцоо нь тайлант хугацаанд мөнгөөр гарсан боловч дараагийн тайлант хугацаанд зардал буюу бараа, үйлчилгээгээр тооцогдох ирээдүй цагийн зарлагыг илэрхийлнэ. Урьдчилгаа буюу урьдчилж төлсөн тооцоо нь мөнгө, бараа материал, үйлчилгээгээр хаагдах тооцоо юм.

Урьдчилж төлсөн зардал нь мөнгө, бараа, үйлчилгээ буцаан авахгүй харин зардал болж,

орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөх зарлагыг илэрхийлнэ.

Урьдчилгаа тооцоог шинж чанараас нь хамааруулан дараах гурван хэсэгт ангилж үзнэ.

Урьдчилж төлсөн тооцоо: Худалдан авах бараа, үйлчилгээний үнийг урьдчилан төлсөн тооцоо болон мөнгөөр төлөөд буцаан мөнгөн хэлбэрээр барагдуулах зориулалтаар үүссэн тооцоог хамааруулна. Тухайлбал: Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа, татварын тооцоо гэх мэт.

Урьдчилж төлсөн зардал: Нэг буюу хэд хэдэн тайлант үед ногдох зардлыг бөөнд нь урьдчилан төлсөнтэй холбоотой үүссэн тооцоог хамааруулах ба эдгээр тооцоо нь системтэйгээр зардал хэлбэрээр хүлээн зөвшөөрөгдөнө. Жишээ нь: урьдчилан төлсөн

даатгалын зардал, үйл ажиллагааны түрээс гэх мэт.

Дотоод тооцоо: Ажилтан албан хаагчдад дараа тооцоо хийхээр олгосон урьдчилгааны тооцоог бүртгэнэ.

7.7 Бараа материал

Нэг жилээс дотогш хугацаанд ашиглах зарим төрлийн хөрөнгийг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс хэмээн хүлээн зөвшөөрч, бараа материалын дансны бүлэгт хангамжийн материал гэсэн хэсэгт бүртгэж болно.

Холбоо нь бараа материалыг орлогод авах, зарцуулах буюу байгууллагын хэрэгцээнд тавьж олгохдоо дундаж өртгийн аргаар зарлагдах бөгөөд бараа материалын байнгын систем ашиглана. Бараа материалын өртгийг цэвэр боломжит үнэ хүртэл бууруулсан аливаа дүн болон бараа материалын бүх гарзыг уг бууруулах бичилт хийгдсэн эсвэл гарз гарсан тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгох ба борлуулах, сольж арилжих буюу түгээн хуваарилахад шаардлагатай тооцоолсон өртөг, зардлыг хассан дүн юм. Бараа материалыг өртгөөр нь бүртгэж, өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлж балансад тусгана.

Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын өртөг мөн одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардал орно.

7.8 Үндсэн хөрөнгө

Үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа, Нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах биет зүйлийг үндсэн хөрөнгө гэнэ.

Үндсэн хөрөнгө тус бүрд тухайн хөрөнгө байгууллагад үр өгөөжөө өгөх тооцоолсон хугацааг үндэслэн ашиглалтын хугацааг байгууллага өөрөө тодорхойлдог. Хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлохдоо байгууллагын түүхэн туршлага, хөрөнгөнд үнэлгээчээс тогтоосон хугацаа, инженерийн үнэлгээ тооцоог удирдамж болгодог.

Үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тайлагнадаг.

Өртөг гэдэг нь хөрөнгө худалдан авах эсвэл барьж байгуулах өдрийн бодит үнэ цэнэ эсвэл төлсөн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн эсвэл СТОУС-д заасан хөрөнгийг хүлээн зөвшөөрөхөд хувиарласан боломжит бусад дүн юм.

Үзүүлэлт	Ашиглалтын хугацаа /жилээр/
Барилга	25 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга эд хогшил	10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	2 жил

Хөрөнгийн үлдэх өртөг гэдэг нь техникийн ашиглалтын нөхцөл болон хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст тухайн хөрөнгө хуучирсан болон ашиглах хугацаа дууссан гэсэн таамаглалд үндэслэн компани нь уг хөрөнгийг борлуулах өдрийн байдлаар хүлээгдэж буй боломжит үнээс борлуулалтын зардлыг хасаж тооцсон дүнг хэлнэ.

Үлдэгдэл өртөг гэдэг нь үндсэн хөрөнгийн анхны өртгөөс ашиглалтын хугацааны туршид хуримтлагдсан элэгдэл болон үнийн бууралтын гарзыг хассан өртөг.

Дахин үнэлсэн үнэ гэдэг нь хөрөнгийн анхны өртөг эсвэл үлдэгдэл өртгийг шинэчлэн тогтоосон дүн.

Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглагдах хугацааг тайлант үе бүрийн эцэст дахин үнэлэх шаардлагатай гэж үзвэл тохируулга хийнэ.

Санхүүгийн түрээс байдлаар түрээслэгчийн эзэмшиж буй хөрөнгийн өртгийг СТОУС 16 "Түрээс"-д зааснаар түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн аль бага дүн дээр түрээслэгчийн төлсөн анхдагч шууд зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Элэгдэл. Газраас бусад үндсэн хөрөнгүүдийг элэгдүүлдэг ба элэгдлийг тооцохдоо ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар үлдэх өртөг хүртэл нь элэгдүүлдэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тэдгээрийн өртгийг холбогдох татварын хууль болон доорх хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь бууруулан хуваарилж тооцно:

Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө үнэ цэнээ алдаж байвал үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг НББОУС-36 "Үнэ цэнийн бууралт"-ын дагуу бүртгэнэ. Хөрөнгийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс их болсон бол үнэ цэнэ буурсан гэж үзнэ. Нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэ болон борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийн аль их нь байна.

Дансны үнэ >Нөхөгдөх дүн тохиолдолд үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын хэмжилтээр үнэ цэнэ буурсан бол уг бууралтыг тайлант үеийн алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан бөгөөд цаашид эдийн засгийн үр өгөөж өгөхгүй болсон тохиолдолд тооллогын комисс, бусад ажлын хэсгийн акт, дүгнэлтийг үндэслэн Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу хөрөнгийг данснаас хасах ажил гүйлгээг бүртгэнэ.

Хөрөнгийн нэр	Барилга	Тээврийн хэрэгсэл	Тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил	Нийт
2023 оны 12-р сарын 31	1,663,000,000.0	372,200,000.0	555,709,996.3	153,009,506.9	2,743,919,503.2
Худалдан авсан			19,868,000.0	44,748,984.2	64,616,984.2
Хасагдсан		145,000,000.0	279,523,273.3	81,166,847.8	505,690,121.1
2024 оны 12-р сарын 31	1,663,000,000.0	227,200,000.0	296,054,723.0	116,591,643.3	2,302,846,366.3
Хуримтлагдсан элэгдэл					
2023 оны 12-р сарын 31	229,484,470.2	246,044,329.1	536,170,292.9	93,536,510.4	1,105,235,602.6
Тухайн жилийн элэгдэл	41,546,544.7	23,448,588.2	21,727,839.3	14,734,887.9	101,571,686.3
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл		143,152,057.8	279,102,875.0	68,075,824.2	490,330,756.9
2024 оны 12-р сарын 31	271,031,014.9	126,340,859.5	278,795,257.2	40,195,574.1	716,476,532.0
Дансны үнэ	1,391,968,985.1	100,859,140.5	17,259,465.8	76,396,069.2	1,586,369,654.3

7.9 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө нь биет шинж чанаргүй ч тодорхойлж болох мөнгөн бус хөрөнгө юм.

Биет бус хөрөнгө дараах шинж чанарыг агуулсан байна.

- Тусгайлан тодорхойлогдохуйц байх,
- Байгууллагын хяналтанд байх,
- Эдийн засгийн ирээдүйн үр өгөөж байгууллагад орж ирэхээр хүлээгдэж байх.

Судалгаа шинжилгээ нь шинжлэх ухаан, техникийн шинэ мэдлэг, санаа хайж олохтой холбоотой төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаа тандалт юм.

Хөгжүүлэлт нь ихээхэн боловсронгуй материал, багаж хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйл явц, систем болон үйлчилгээг бий болгох, түүнийг үйлдвэрлэл болон хэрэглээнд нэвтрүүлэх

хүртлэх судалгаа шинжилгээний болон бусад мэдлэгийг хэрэглэх үйл ажиллагаа юм.

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг худалдан авалт хийсэн өдөр өртгөөр нь бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн өртөг гэдэг нь тухайн хөрөнгийг худалдан авах, бий болгох үеийн бодит үнэ цэнэ буюу төлсөн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн юм.

Үлдэх өртөг гэдэг нь хөрөнгийн ашиглагдах хугацааны эцэст ашиглалтаас хасахтай холбогдон гарахаар хүлээгдэж буй зардлуудыг хассаны дараа тухайн хөрөнгөнд байж болох цэвэр мөнгөн дүн юм.

Дансны үнэ гэж санхүүгийн тайланд байгаа үлдэх өртөг буюу анхны өртгөөс хуримтлагдсан хорогдуулалтыг хассаны дараах хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн дүн юм.

Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа биет бус хөрөнгийг анхны өртгөөс хорогдуулалт ба үнэ цэнийн бууралтын хуримтлагдсан алдагдлыг хассан өнөөгийн цэвэр үнэ цэнээр санхүүгийн тайланд тусгана.

Хорогдуулалт нь хөрөнгийн хорогдуулах өртгийг ашиглалтынх нь хугацааны туршид системтэйгээр тооцсон хуваарилалт юм.

Хорогдуулах дүн нь хөрөнгийн анхны өртөг эсвэл өртөг хэмээн төлөөлүүлэн зөвшөөрсөн дүнгээс үлдэх өртгийг хассан дүн юм.

Хөрөнгийн нэр	Патент	Программ хангамж	Нийт
2023 оны 12-р сарын 31	352,933,284.0	371,470,000.0	724,403,284.0
Худалдан авсан			
Хасагдсан		366,850,000.0	366,850,000.0
2024 оны 12-р сарын 31	352,933,284.0	4,620,000.0	724,403,284.0
Хуримтлагдсан элэгдэл			-
2023 оны 12-р сарын 31	227,976,354.9	371,470,000.0	599,446,354.9
Тухайн жилийн элэгдэл	35,370,642.6		35,370,642.6
Данснаас хассан		366,850,000.0	366,850,000.0
хөрөнгийн элэгдэл			
2024 оны 12-р сарын 31	263,346,997.5	4,620,000.0	267,966,997.5
Дансны үнэ	89,586,286.5	-	89,586,286.5

Биет бус хөрөнгийн тайлангаас харахад хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүд байгаа нь тус хөрөнгүүдийн цаашид ашиглах боломж, хугацааг харгалзан дахин үнэлгээний асуудлыг авч үзэх шаардлагатайг харуулж байна.

7.10 Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
Бусад хөрөнгө	118,649,000.0	

Үндэсний хөрөнгө оруулалтын банк ХХК болон Албан журмын даатгагчдын холбоо ГҮТББ хооронд 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хийгдсэн №24/123 дугаартай Эрх шилжүүлэх гэрээний дагуу Орон сууцны захиалгын гэрээг шилжүүлэн авсан.

7.11 Өр төлбөр

Өр төлбөр гэдэг нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн үр өгөөжийг өөртөө агуулж байгаа нөөцөөс гарах үр дүнд хүлээгдэж буй төлбөр тооцоо болон өнгөрсөн үйл явдлаас үүссэн өнөөгийн хүлээх үүрэг юм.

Одоо байгаа өр төлбөрийг барагдуулснаар эдийн засгийн үр ашгийг агуулж байгаа нөөц буурах магадлалтай бөгөөд хэмжигдэх бүрэн боломжтой өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Өр төлбөрийг дараах аргаар хэмжиж бүртгэнэ.

- Анхны өртөг - бизнесийн хэвийн нөхцөлд өр төлбөрийг төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн
- Төлөгдөх боломжит дүн - Бизнесийн хэвийн нөхцөлд өрөө төлж барагдуулахад шаардагдаж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дискаунтчилаагүй дүн
- Өнөөгийн үнэ цэнэ - Бизнесийн хэвийн нөхцөлд өрөө төлж барагдуулахад шаардагдаж байгаа ирээдүйн цэвэр мөнгөн зарцуулалтын дискаунтчилсан дүн.

Өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнээр буюу өртгөөр нь бүртгэнэ. Бодит үнэ цэнэ гэдэг нь гэрээнд заасан үнийн дүнгээс хөнгөлөлт, хасагдуулгыг хассан цэвэр дүн юм.

Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор бараа, ажил үйлчилгээ, материал, сэлбэг худалдан авснаар бэлтгэн нийлүүлэгч, ажил гүйцэтгэгчдэд төлөх өр төлбөрийг дансны өглөгөөр бүртгэнэ.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх дутуу төлөгдсөн дүнг хамааруулан бүртгэдэг.

Зээл. Компанийн үйл ажиллагаанд зориулан банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийг бүртгэдэг. Зээлийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр тооцож бүртгэдэг.

Өр төлбөрийг богино ба урт хугацаат гэж ангилж тайлагнана.

1. Богино хугацаат өр төлбөр
2. Урт хугацаат өр төлбөр

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), бусад татвар, төлбөр,

хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх дутуу төлөгдсөн дүнг хамааруулан бүртгэдэг.

Зээл. Компанийн үйл ажиллагаанд зориулан банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийг бүртгэдэг. Зээлийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр тооцож бүртгэдэг.

7.11.1 Дансны өглөг

	2024.12.31	2023.12.31
Байгууллагад өгөх өглөг	2,420,216.0	2,104,408.0

7.11.2 Татварийн өр

	2024.12.31	2023.12.31
Татварын өр		
ААНОАТ өглөг	18,521,424.7	280,000.0
ХХОАТ өглөг	4,274,489.2	

7.11.3 Бусад өр

	2024.12.31	2023.12.31
Бусад өглөг	150,000.0	199,000.0

Бусад өглөг дансанд ажилчдад өгөх өглөг, хувь хувь хүмүүст өгөх өглөг тусгагдсан байна.

7.12 Цэвэр хөрөнгө буюу өөрийн хөрөнгө

Төрийн бус байгууллагад хяналтанд байгаа нийт нөөцийг хязгаарлалттай болон хязгаарлалтгүй хэмээн ангилж, санхүүгийн байдлын тайланд харуулна.

Хязгаарлалттай нөөц нь хандивлагчийн зүгээс эсвэл хуулийн дагуу ашиглалтын нөхцөлд нь хязгаарлалт тавьсан өмч.

Хязгаарлалтгүй нөөц нь байгууллагын бүрэн мэдэлд байгаа өмч.

ТББ-ын цэвэр хөрөнгө дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- Нөөц
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл
- Хуримтлагдсан үр дүн

Цэвэр хөрөнгийн хэмжилт ба үнэлгээ

Нөөц нь хандивлагч, гишүүдийн зүгээс оруулсан болон үйл ажиллагааны явцад нэмж оруулсан хөрөнгийн дүнгээр илэрхийлэгдэнэ.

Хөрөнгийн дахин үнэлгээний улмаас хөрөнгийн үлдэгдэл өртөг нэмэгдсэн тохиолдолд зөрүүгээр цэвэр хөрөнгийн хэсэгт дахин үнэлгээний нэмэгдлийг бүртгэнэ. Дахин үнэлгээгээр хөрөнгийн үлдэгдэл өртөг буурсан бол дахин үнэлгээний бууралтыг тайлант

үеийн алдагдал болгон үр дүнгийн тайланд харуулна. Өмнө үнэлсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр үлдэгдэл өртөг буурсан бол дахин үнэлгээний бууралтыг өмнө бүртгэсэн дахин үнэлгээний нэмэгдэл (хэрэв байгаа бол) эсвэл хорогдуулна.

Дахин үнэлэгдсэн хөрөнгийг данснаас хасах, устгах, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үед дахин үнэлгээний нэмэгдсэн хэмжээ бодитой болсон гэж үзэж дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан үр дүнд шилжүүлнэ.

Холбоо үүсгэн байгуулагдсанаас хойшхи хугацаанд хуримтлагдсан ашиг, алдагдлыг тайлант жилийн эцэст хаалтын гүйлгээ хийж, тухайн жилийн цэвэр ашиг, алдагдлыг тодорхойлно. Тайлант үеийн болон өмнөх жилийн хуримтлагдсан ашиг алдагдлууд хязгаарлалтай нөөц сан руу хаагдана.

Цэвэр хөрөнгө	2024.12.31	2023.12.31
Нөөц: а) хязгаарлалтгүй	10,000,000.0	10,000,000.0
б) хязгаарлалттай	20,477,955,161.7	19,759,857,031.8
Дүн	20,487,955,161.7	19,769,857,031.8

Холбооны цэвэр хөрөнгө нь хязгаарлалттай ба хязгаарлалтгүй нөөц сангуудаас бүрдэх ба Хязгаарлалттай нөөц сан нь Даатгалын тухай хуулийн 12.6 дахь хэсэг, Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1 дэх хэсэгт заасан эх үүсвэрээс бүрдэнэ. Тайлант оны үр дүн 711,149,427.05 төгрөгийн цэвэр ашиг Хязгаарлалттай нөөц сан руу хаагдсан.

7.13 Цэвэр хөрөнгийн өмчийн бусад хэсэг

	2024.12.31	2023.12.31
Цэвэр хөрөнгийн өмчийн бусад хэсэг	5,864,268.5	12,812,971.3

Цэвэр хөрөнгийн бусад хэсэгт дээрх хууль тогтоомжид тусгайлан зохицуулагдаагүй эх үүсвэртэй холбоотой гүйлгээний үлдэгдлийг тусгасан байна.

7.14 Орлого, зардал

Орлого нь үйл ажиллагааны орлого болон үйл ажиллагааны бусад орлого, олзыг багтаана. Үйл ажиллагааны орлогод гишүүдийн татвар, хураамжийн орлого, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлж олсон орлого, үйл ажиллагааны бусад орлогод хүү, ногдол ашиг, эрхийн шимтгэл зарим хөрөнгийн ашиглалтын (түрээсийн) орлого зэрэг хамрагдана.

Зардал гэдэг нь тайлангийн хугацааны туршид байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотойгоор гарах цэвэр хөрөнгийн бууралт юм. Зардал нь борлуулалтын өртөг, үйл ажиллагааны зардал болон бусад үйл ажиллагааны бусад зардал, гарзыг багтаана. Зардлыг аккрузал суурьт үндэслэн бүртгэнэ. Санхүүгийн тайлангийн жилийн өмнөх ба дараагийн үеийн үйл ажиллагаанд хамааралтай зүйлсийн төлбөр нь зардалд хамаарахгүй.

Үйл ажиллагааны бус зардалд хандив тусламжийн зардал, торгуулийн зардал, үндсэн хөрөнгийг данснаас хасахад үүссэн алдагдал, нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан хөрөнгө, гадаад валютын ханшийн өөрчлөлтийн алдагдлыг тус тус тусгана.

Холбооны үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт нь гишүүн байгууллагуудын татвар, мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсаны орлого, даатгагчдаас төвлөрүүлсэн шимтгэлийн орлогоос бүрдэнэ. Дараа онд бүрдүүлэх гишүүний элсэлтийн хураамж болон дараа жилд гишүүний татварын хэмжээ, даатгагчдаас төвлөрүүлэх шимтгэлийн орлого зэргийг жил бүрийн эцэст Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тогтоодог.

7.14.1 Борлуулалтын орлого

Үзүүлэлт	2024.12.31	2023.12.31
Гишүүдийн татвар	17,000,000.0	
Программ ашиглалтын орлого	190,474,500.0	165,464,500.0
Даатгагчдаас төвлөрүүлсэн хөрөнгийн орлого	663,877,072.4	557,852,843.0
Хүү/бусад орлого	1,836,918,945.7	1,770,039,957.5
Дүн	2,708,171,518.2	2,493,357,300.5

Нийт орлогын 66%-ийн банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого эзэлж байна.

Даатгалын зууч байгууллагууд нь "Мэдээллийн нэгдсэн систем"-ийг ашиглаж хийсэн гэрээ тутамдаа 500 төгрөгийн программ ашиглалтын төлбөр төлдөг.

Зардал гэдэг нь тайлангийн хугацааны туршид байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотойгоор гарах цэвэр хөрөнгийн бууралт юм. Зардлыг аккрузал суурьт үндэслэн бүртгэнэ. Холбооны үйл ажиллагааны зардлыг Жолоочийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан зориулалт, Удирдах зөвлөлөөс баталсан тухайн жилийн төсөвт багтаан санхүүжүүлнэ.

Үйл ажиллагааны бус зардалд хандив тусламжийн зардал, торгуулийн зардал, үндсэн хөрөнгийг данснаас хасахад үүссэн алдагдал, нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан хөрөнгө, гадаад валютын ханшийн өөрчлөлтийн алдагдлыг тус тус тусгана.

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг бүртгэхдээ ажил гүйлгээ гарсан өдрийн Монгол банкнаас зарласан хаалтын ханшийг үндэслэн төгрөгт хөрвүүлж бүртгэнэ.

7.14.2 Үндсэн үйл ажиллагааны зардал

	2024.12.31	2023.12.31
Цалингийн зардал	592,311,036.0	477,257,093.0
НДШ-ийн зардал	62,763,940.8	51,473,943.6
Засвар үйлчилгээний зардал	112,617,550.0	12,416,010.0
Ашиглалтын зардал	45,663,878.7	48,039,303.5
Түрээсийн зардал	2,940,000.0	35,109,553.0
Албан томилолтын зардал	53,968,295.0	21,283,317.0
Даатгал, оношлогоо, татварын зардал	17,125,667.0	19,291,673.0
Элэгдлийн зардал	133,059,977.6	183,348,120.0
Зар сурталчилгааны зардал	164,798,955.0	89,738,417.0
Шуудан, холбооны зардал	23,570,108.4	29,761,013.3
Шатахууны зардал	5,694,400.0	6,011,444.0
ОАТатварын зардал	184,697,573.5	171,271,178.6
Бусад зардал	509,786,389.3	10,649,153,595.5
Найдваргүй авлагын зардал	81,075,597.0	
Дүн	1,990,073,388.4	11,794,154,861.6

Удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн №04 дугаартай хуралдаанаар баталсан "Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг цахимжуулах ажил"-ыг эхлүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдөр 455,000,000.0 төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Энэ нь бусад зардлын 89.25%-ийг эзэлж байна.

7.15 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага.

Бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад байгууллагын эсрэг төрөл бүрийн үүрэг хариуцлага үүсч болно. Тайлант хугацаанд болзошгүй өр төлбөр үүсч болох аливаа шинж тэмдэг ажиглагдаагүй болно.

8. АУДИТЫН ТАЙЛАН

8.1 Ерөнхий зүйл

Аудитын тухай хуулийн дүгээр зүйлийн 4.1. "Энэ хууль болон Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд аудитын үйл ажиллагаа эрхэлнэ." гэж заасны дагуу Албан журмын даатгагчдын холбоо ГҮТББ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитыг танилцуулж байна.

Албан журмын даатгагчдын холбоо ГҮТББ болон Шонхор үнэлгээ Аудит ХХК нь 2025 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 25/14 тоот гэрээ байгуулсан.

Аудитыг Аудитор Д.Шийрэв, аудиторов туслах Ц.Гэрэлцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Д.Уранчимэг хяналтыг хэрэгжүүлсэн.

8.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АОУС 320 дагуу тодорхойлж материаллаг байдлын эрсдлийг "дунд" гэж үнэлсэн.

Материаллаг байдал тооцох сууриар нийт орлогыг сонгож, 2,708,171,518 (хоёр тэрбум долоон зуун найман сая нэг зуун далан нэгэн мянга таван зуун арван найман) төгрөгөөс 1.0 хувиар буюу 27,081,715 (хорин долоон сая наян нэгэн мянга долоон зуун арван таван) төгрөгөөр тогтоолоо.

8.3 Бусад хууль, тотоомжийн хүрээнд

1. Санхүүгийн зохицуулах хорооны журам хэрэгжүүлэх хүрээнд:

1. Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг Сэндли ББСБ ХХК-д итгэлцлээр байршуулахдаа Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлөөс 150,000,000 (Нэг зуун тавин сая) төгрөгийг хэтрүүлэн байршуулсан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 2131 дугаар тоолоор баталсан "Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам"-ын 3.6-д заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сэндли ББСБ ХХК-д итгэлцлийн гэрээгээр шилжүүлсэн 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөгийг байршуулах зөвшөөрлийг холбогдох байгууллагаар нөхөж гаргуулах, эсвэл хөрөнгийг журамд нийцүүлэн өөр зөвшөөрөгдсөн байгууллага, хэлбэрээр байршуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2. Албан журмын даатгагчдын холбооны гишүүний татварын хэмжээг тогтоосон холбооны Удирдах зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 30 дугаар тогтоол нь 2017 онд хамаарах агуулгатай бөгөөд дахин шинэчлэн батлаагүй бөгөөд одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан журмын даатгагчдын холбооны гишүүний татвар төлөх тогтоолыг шинэчлэх судлан шийдвэрлэх шаардлагатай байна.

2. Холбооны удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын эрх үүрэг хэрэгжүүлэх хүрээнд:

“Мэдээллийн нэгдсэн систем”-ийн сайжруулалтад зарцуулсан 455,000,000.0 (дөрвөн зуун тавин таван сая) төгрөгийг зарцуулах Холбооны Удирдах зөвлөлийн тогтоол гараагүй нь холбооны удирдах зөвлөл гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний 4.1.14 дэх заалтын зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбооны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14 “Холбооны удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирлын гаргасан шийдвэр хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг зөрчсөнийг илрүүлсэн болон тогтоогдсон бол шийдвэр гаргагч этгээд өмнөх шийдвэрийг хүчингүй болгох тэдгээрт нийцүүлж өөрчлөх эрхтэй” гэж заасны дагуу шийдвэрлэх

8.4 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 683,08 сая төгрөгийн 7 асуудалд зөвлөмж хүргүүлсэн боловч авлагын хасагдуулгын нөөц данс ашиглах тухай 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна

Хэрэгжээгүй зөвлөмжийн шалтгааныг тодруулбал:

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсаны үндсэн дээр тайлан гаргаж байх зөвлөмжийг өгсөн боловч тооцоо нийлэх боломжтой 42 харилцагчийн 6,317,713,709.45 үлдэгдлээс 7 харилцагчийн 93,136,441.6 сая төгрөгийн тооцоо нийлсэн нь нийт авлагын 1.5 хувийг эзэлж байна.
2. Бараа материалын худалдан авалт зарцуулалтыг бараа материалын дансаар дамжуулан орлого зарлагын бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн хөтлөх тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.
3. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт буюу төлбөрийн и-баримтгүйгээр бүртгэлийг хөтөлсөн нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14. “төлбөрийн баримт” гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг; хэлнэ гэсэнтэй нийцэхгүй байгаа тухай зөвлөмжийг хүргүүлсэн боловч 2024 оны тайлангаар Борлуулалтын дүнгийн 85.13 хувь буюу 741,764,940.17 төгрөгийн баримтыг бичээгүй байна.
4. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлийн үйл ажиллагаатай холбоотой эрсдлийг урьдчилан сэргийлэх дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлээгүй байна. Цаашид холбооны дотоод хяналтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байх зөвлөмж өгсөн ч хэрэгжүүлээгүй байна.

8.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Холбооны 2023, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах,

Албан журмын даатгагчдын холбооны "Мэдээллийн нэгдсэн систем"-ийн сайжруулалтад зарцуулах хөрөнгийг СТОУС 38-д заасан шалгуурын дагуу биет бус хөрөнгөөр бүртгэх эсэх талаар холбооны гүйцэтгэх удирдлагын зүгээс хэрэгжүүлсэн ажил, авсан арга хэмжээг шалгах.

9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

1. Хувь хүний орлогын албан татвар авлага болон өглөг 2 талдаа үлдэгдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын албатай тооцоо нийлж баталгаажуулах

2. Өмнөх аудитын зөвлөмжөөр өгөгдсөн 7 асуудлын 6 асуудлыг биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭЙТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны тооц утга	Нийт алдаа		Мэдээлэл тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Загруулсан		Загруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Хувь хүний орлогын албан татвар азлага болон өглөг талдаа 2 үлдэгдэлтэй байна. Өмнөх аудитын зөвлөмжөөр өнгөрсөн 7 асуудлын 3 асуудлыг биелүүлээгүй байна.	1	1,3									1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг Сэндли БЕСБ ХХК-д итгэлцлээр байршуулахдаа СЗХ-ны зөвшөөрлөөс 150,000,000 (Нэг зуун тавин сая) төгрөгөөр хэтрүүлэн байршуулсан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 2131 дугаар тослоор баталсан "Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам"-ын 3.6-д заасантай нийцэхгүй байна.	1	150,000.0					1	-
Албан журмын даатгагчдын холбооны гишүүний татварын хэмжээг тогтоосон холбооны Удирдах зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 30 дугаар тогтоол нь 2017 онд хамаарах агуулгатай бөгөөд дахин шинэчлэн батлаагүй бөгөөд одоог хүртэл хүчин тэгэлдөр мөрдөж байна.								
"Мэдээллийн нэгдсэн систем"-ийн сайжруулалтад зарцуулсан 455,000,000.0 (дөрвөн зуун тавин таван сая) төгрөгийг зарцуулах Холбооны Удирдах зөвлөлийн тогтоол гараагүй нь холбооны удирдах зөвлөл гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний 4.1.14 дэх заалтын зөрчлөн байна.	1	455,000.0					1	455 000.0
Дүн	1	605,000.0					1	605,000.0